



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/194

Арвайхээр

“Малчдыг дэмжих анхдугаар аян”-ыг зохион  
байгуулах ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малчдыг дэмжих, мэдээллээр хангах аянг өрнүүлж, тэдгээрийн мэдлэг, туршлага, чадавхыг сайжруулах, хөгжүүлэх, залуу малчдыг бэлтгэх зорилгоор “Малчдын анхдугаар аян”-ыг 2023 оны 04 дүгээр сарын 01-ээс 11 дүгээр сарын 15-ыг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. “Малчдыг дэмжих анхдугаар аян”-ны ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. “Малчдыг дэмжих анхдугаар аян”-ыг өрнүүлж, хэрэгжүүлэх, хөрөнгө санхүүг төсөвт суулгах, зохион байгуулалтын явц, үр дүнг дүгнэж тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т болон сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0356

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дугаар сарын 01-ны өдрийн 191 дугаар захирамжийн хавсралт

МАЛЧДЫГ ДЭМЖИХ АНХДУГААР АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ


Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулах хөрөнгийн эх үүсвэр	Хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх түвшин, үр дүн
1.	Малчдын зөвлөгөөн зохион байгуулах	2023 оны 05-07 сард	Орон нутгийн төсөв, Төсөл хөтөлбөр	ХХААГазар, ХБТХОХ МЭГ, BEST-хөтөлбөр	Сумдад малчдын зөвлөгөөн зохион байгуулж малчдыг мэдлэгжүүлж, чадвахжуулсан байна.
2.	Өрхийн аж ахуйд шаардлагатай бага оврын тоног төхөөрөмж болон борлуулалтын дэмжлэг үзүүлэх.	2023	Орон нутгийн төсөв	ХХААГазар, ХБТХОХ	Өрхийн аж ахуйд шаардлагатай бага оврын тоног төхөөрөмж болон борлуулалтын дэмжлэг үзүүлсэн байна.
1.	Залуу малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах, тэдгээрийн мэдлэг, туршлага, чадавхыг сайжруулах, хөгжүүлэх мал маллах уламжлалт соёлд сургахад ахмад малчдаас зөвлөх үйлчилгээг авах	2023	Орон нутгийн төсөв	ХААГазар, ХБТХОХ	Ахмад малчдын тэргүүн туршлага, уламжлалт мэдлэгийг олон нийтэд сурталчилан түгээсэн байна.
5.	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн амжилттай эрхэлж байгаа залуу малчин өрхийн сайн жишээг подкаст, стори хэлбэрээр малчид болон нийгэмд хүргэх сурталчлах	2023	Орон нутгийн төсөв	ХХААГазар, ХБТХОХ	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн амжилттай эрхэлж байгаа залуу малчин өрхийн сайн жишээг подкаст, стори хэлбэрээр малчид болон нийгэмд хүргэх сурталчилсан байна.



6.	Мал аж ахуйн бизнес маркетингийг хөгжүүлэх	2023	Орон нутгийн төсөв	ХХААГазар, ХБТХОХ	Малчин өрхийн орлогыг бууруулахгүйгээр бэлчээрийн даацаас хэтэрсэн малын тоог үе шаттай бууруулах, хэрэгцээнээс давсан малыг борлуулах, нэвтрүүлэх, мэдлэг чадварт сургасан байна.
7.	Түүхий эдийн гарал үүсэл, мөшгөх системийг тогтворжуулах	2023	Орон нутгийн төсөв	ХБТХОХ, МЭГ	MNS 6891:2020 “Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага стандартыг сурталчлан таниулах”
8.	Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг стандартын дагуу бэлтгэн нийлүүлэх технологийн сургалтыг зохион байгуулах	2023	Орон нутгийн төсөв, Төсөл хөтөлбөр	ХХААГазар, ХБТХОХ МЭГ, BEST-хөтөлбөр	Малчид малын гаралтай түүхий эдийг стандартын дагуу бэлтгэн нийлүүлэх талаар мэдлэг мэдээлэлтэй болсон байна.
9.	Малчдад гарын доорх материалаар дарш бэлтгэх, мал тэжээх, бордох технологийн сургалт зохион байгуулах.	2023 оны 06-08 сар	Орон нутгийн төсөв, Төсөл хөтөлбөр	ХХААГазар, ХБТХОХ МЭГ, BEST-хөтөлбөр	Малчид гарын доорх материалаар дарш бэлтгэж, мал тэжээх, бордох технологийн талаар мэдлэг мэдээлэлтэй болсон байна.



байгууллагаар гүйцэтгүүлэх Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссоос энэ чиглэлээр тусгайлан өгсөн үүргийг хэрэгжүүлэх.



2.1.2. Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах.

2.1.3. Гамшгийн үед цагийн байдалд мэргэжлийн байгууллагаас өгсөн үнэлэлт, дүгнэлт авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцэж, шийдвэр гаргах.

2.1.4. Гамшгийн голомтод Засгийн газар, олон улсын хүмүүнлэгийн байгууллагаас олгосон бараа материал, тусламжийг хүргэх болон тээвэрлэх явцад хяналт тавих.

2.1.5. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, нэрвэгдэгсдэд шуурхай тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх ажилд шаардагдах хүн хүч, техник хэрэгслийг зохих журмын дагуу дайчлан гаргах асуудлыг орон нутгийн төр захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтантай хамтран шийдвэрлэж, зохицуулах шаардлагатай нэмэгдэл хүн, хүч, техник хэрэгслийг дайчлан гаргах.

2.1.6. Гамшгийн аюулаас хүн ам, мал амьтан, хүрээлэн байгаа орчныг аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүч хүрэлцэхгүй болсон үед дээд шатны онцгой комисст албан ёсны хүсэлт тавих.

2.1.7. Комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж байх.

2.1.8. Гамшиг тохиолдсон үед хохирол, хэрэгцээг тодорхойлох, үнэлэх ажлын хэсгийг зохих мэргэжлийн алба хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулж дүгнэлт гаргах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулах

2.2. Комисс дараах эрхтэй байна.

2.2.1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар орон нутгийн төрийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих.

2.2.2. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд орон нутгийн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, гадаадын хөрөнгө оруулалттай болон дотоодын аж ахуйн нэгж, иргэдийг хууль тогтоомжийн дагуу өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан татан оролцуулах.

2.2.3. Холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ мэдээлэлд судалгаа гаргуулан авах, илтгэл мэдээллийг хурлаараа хэлэлцэж шийдвэр гарган биелүүлэхийг шаардах, хяналт тавих.